**ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2025/027/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn
Мөрөн сум
2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг:tegshdelgerb@audit.gov.mn
Аудитор: Б.Ариунтуяа
Утас:99036832 Цахим хаяг: ariuntuyab@audit.gov.mn
Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа
Утас:99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com
Аудитор Ц.Мөнхтуяа
Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/181

танай ______ -ны № ______ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН АЛАГ-ЭРДЭНЭ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА О. БАДМАА ТАНАА

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Алаг-Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төв нь 2024 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,030,356.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авахаас 945,285.2 мянган төгрөгийг санхүүжилтийг авч 85,070.8 мянган төгрөгийн авлагатай гарсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар илрүүлсэн нийт 11,293.2 мянган төгрөгийн 7 зөрчилд зөвлөмж өглөө.

**Бусад асуудлын хэсэг**

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Алаг-Эрдэнэ сумын эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2024 оны гэрээний биелэлтийг 89.5 хувьтай дүгнэсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

6720022028

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **92,539,717.64** | **170,749,840.75** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 1,752,229.19 | 29.74 |
| **312** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | 1,752,229.19 | 29.74 |
| **3121** | **Төгрөг** | 1,752,229.19 | 29.74 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 1,752,229.19 | 29.74 |
| **33** | **АВЛАГА** | 19,928,003.00 | 85,070,777.75 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 19,928,003.00 | 85,070,777.75 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 70,859,485.45 | 85,679,033.26 |
| **351** | **Түүхий эд материал** | 21,345,554.76 | 33,985,796.51 |
| 35130 | Эм боох материал | 21,345,554.76 | 33,985,796.51 |
| **354** | **Хангамжийн материал** | 49,513,930.69 | 51,693,236.75 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 0.00 | 85,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 13,001,029.00 | 12,243,029.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 8,260,000.00 | 7,000,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 3,803,317.00 | 895,750.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 24,449,584.69 | 31,469,457.75 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **323,580,850.87** | **525,441,380.04** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 323,580,850.87 | 525,441,380.04 |
| **392** | **Биет хөрөнгө** | 309,820,850.95 | 511,857,380.16 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 235,267,390.00 | 235,267,390.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (34,372,007.36) | (40,183,353.20) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 38,320,000.00 | 217,319,366.47 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (34,643,833.48) | (10,079,285.25) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 149,871,211.29 | 164,725,796.69 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (72,184,718.35) | (79,500,909.86) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 37,201,000.00 | 36,549,000.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (9,638,191.15) | (12,240,624.69) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 13,759,999.92 | 13,583,999.88 |
| 39301 | Программ хангамж | 880,000.00 | 880,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (352,000.08) | (528,000.12) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 13,232,000.00 | 13,232,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **416,120,568.51** | **696,191,220.79** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **11,521,761.30** | **34,876,365.44** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 11,521,761.30 | 34,876,365.44 |
| **413** | **Өглөг** | 11,521,761.30 | 34,876,365.44 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 0.00 | 12,323,806.94 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 11,401,554.00 | 19,104,058.50 |
| **4136** | **Бусад өглөг** | 120,207.30 | 3,448,500.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 0.00 | 3,448,500.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 120,207.30 | 0.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **404,598,807.21** | **661,314,855.35** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 404,598,807.21 | 661,314,855.35 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 333,916,115.00 | 333,916,115.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 333,916,115.00 | 333,916,115.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 349,947.08 | 257,065,995.22 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 349,947.08 | 349,947.08 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 256,716,048.14 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 70,332,745.13 | 70,332,745.13 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **416,120,568.51** | **696,191,220.79** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **760,299,863.94** | **1,361,178,718.87** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **39,471,325.82** | **268,485,929.13** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 39,471,325.82 | 268,485,929.13 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **720,828,538.12** | **1,092,692,789.74** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 300,000.00 | 43,368,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 300,000.00 | 43,368,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 29,735,000.00 | 38,896,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 29,735,000.00 | 38,896,800.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 690,793,538.12 | 1,010,427,989.74 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 690,793,538.12 | 1,010,427,989.74 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **808,794,002.20** | **1,104,462,670.73** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **808,794,002.20** | **1,104,462,670.73** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 808,785,546.78 | 1,060,759,450.19 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 525,484,161.95 | 748,608,939.54 |
| 210101 | Үндсэн цалин | 343,832,873.13 | 430,502,493.44 |
| 210102 | Нэмэгдэл | 140,246,252.82 | 252,640,711.10 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,582,000.00 | 18,552,000.00 |
| 210104 | Урамшуулал | 35,823,036.00 | 46,913,735.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 64,587,473.78 | 89,620,152.78 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 45,785,675.89 | 62,113,783.09 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,253,639.58 | 7,475,744.90 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,202,911.57 | 4,543,548.90 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 849,567.96 | 3,092,796.59 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,495,678.78 | 12,394,279.30 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 25,012,544.58 | 36,630,604.46 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,966,544.58 | 4,220,604.46 |
| 210302 | Түлш, халаалт | 21,046,000.00 | 32,410,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 39,776,099.30 | 29,395,948.76 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,165,300.00 | 1,698,280.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,133,335.00 | 21,453,440.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,109,600.00 | 2,499,178.76 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,750,845.70 | 2,143,650.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 318,000.00 | 90,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 14,299,018.60 | 1,511,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 87,606,915.99 | 84,055,692.95 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 73,025,236.99 | 67,353,215.95 |
| 210502 | Хоол, хүнс | 14,581,679.00 | 14,077,477.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 0.00 | 2,625,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,502,250.00 | 3,490,975.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,502,250.00 | 3,490,975.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 320,000.00 | 0.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 320,000.00 | 0.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,098,536.00 | 15,231,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 623,000.00 | 13,433,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,152,000.00 | 0.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 54,450.00 | 55,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 79,710.00 | 99,810.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,940.00 | 33,150.00 |
| 210807 | Газрын төлбөр | 39,786.00 | 35,040.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,115,650.00 | 1,575,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 57,397,565.18 | 53,726,136.70 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,675,320.00 | 11,302,514.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 43,722,245.18 | 42,423,622.70 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 8,455.42 | 43,703,220.54 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 43,668,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 43,368,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 300,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 8,455.42 | 35,220.54 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,455.42 | 35,220.54 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(48,494,138.26)** | **256,716,048.14** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(48,494,138.26)** | **256,716,048.14** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **700,900,535.12** | **1,027,550,014.99** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **700,900,535.12** | **1,027,550,014.99** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 300,000.00 | 43,368,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 300,000.00 | 43,368,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 29,735,000.00 | 38,896,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 29,735,000.00 | 38,896,800.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 670,865,535.12 | 945,285,214.99 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 670,865,535.12 | 945,285,214.99 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **707,490,535.67** | **1,029,302,214.44** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **707,490,535.67** | **1,029,302,214.44** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **707,482,080.25** | **985,598,993.90** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 528,747,292.90 | 730,962,092.68 |
| 210101 | Үндсэн цалин | 309,872,301.33 | 409,972,484.49 |
| 210102 | Нэмэгдэл | 133,718,702.24 | 250,875,031.42 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,726,866.63 | 22,333,000.00 |
| 210104 | Урамшуулал | 54,429,722.70 | 47,781,576.77 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 20,999,700.00 | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 61,154,391.77 | 95,063,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 39,811,491.77 | 65,443,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,335,700.00 | 7,405,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,268,900.00 | 3,702,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,066,700.00 | 3,702,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,671,600.00 | 14,810,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 26,226,544.58 | 35,370,604.46 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,966,544.58 | 4,220,604.46 |
| 210302 | Түлш, халаалт | 22,260,000.00 | 31,150,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 23,576,285.00 | 27,365,319.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,619,400.00 | 1,444,580.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,548,335.00 | 21,151,440.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,104,600.00 | 2,200,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,037,950.00 | 2,284,299.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 266,000.00 | 285,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 44,453,360.00 | 66,593,710.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 33,666,820.00 | 49,796,100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 9,726,540.00 | 14,172,610.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,060,000.00 | 2,625,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,117,250.00 | 4,425,975.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 615,000.00 | 935,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 5,502,250.00 | 3,490,975.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 320,000.00 | |
| 210702 | Дотоод албан томилолт | 320,000.00 | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,211,636.00 | 15,548,878.76 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 623,000.00 | 13,817,178.76 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,152,000.00 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 55,000.00 | 55,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,000.00 | 80,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 42,886.00 | 58,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 30,000.00 | 30,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,228,750.00 | 1,508,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 13,675,320.00 | 10,269,014.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,675,320.00 | 10,269,014.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **8,455.42** | **43,703,220.54** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 43,668,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 43,368,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 300,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 8,455.42 | 35,220.54 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,455.42 | 35,220.54 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(6,590,000.55)** | **(1,752,199.45)** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **1,560,000.00** | |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,560,000.00** | |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 1,560,000.00 | |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,560,000.00 | |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(1,560,000.00)** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (8,150,000.55) | (1,752,199.45) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 9,902,229.74 | 1,752,229.19 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 1,752,229.19 | 29.74 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 333,916,115.00 | 70,332,745.13 | 48,844,085.34 | 453,092,945.47 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 333,916,115.00 | 70,332,745.13 | 48,844,085.34 | 453,092,945.47 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | (48,494,138.26) | (48,494,138.26) |
| D01 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 333,916,115.00 | 70,332,745.13 | 349,947.08 | 404,598,807.21 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 333,916,115.00 | 70,332,745.13 | 349,947.08 | 404,598,807.21 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 256,716,048.14 | 256,716,048.14 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **333,916,115.00** | **70,332,745.13** | **257,065,995.22** | **661,314,855.35** |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**Улсын төсвийн гүйцэтгэл:**

/Төгрөгөөр/

| Данс | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Зөрүү |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,075,004,600.00 | 990,405,414.44 | 92.13 | 84,598,885.56 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,075,004,600.00 | 990,405,414.44 | 92.13 | 84,598,885.56 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 994,704,600.00 | 946,737,414.44 | 95.18 | 47,966,885.56 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 753,317,600.00 | 730,962,092.68 | 97.03 | 22,355,507.32 |
| 210101 | Үндсэн цалин | 541,582,000.00 | 409,972,484.49 | 75.70 | 131,609,515.51 |
| 210102 | Нэмэгдэл | 141,002,000.00 | 250,875,031.42 | 177.92 | -109,873,031.42 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 14,036,000.00 | 22,333,000.00 | 159.11 | -8,297,000.00 |
| 210104 | Урамшуулал | 56,697,600.00 | 47,781,576.77 | 84.27 | 8,916,023.23 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 95,063,400.00 | 95,063,400.00 | 100.00 | 0.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 64,832,000.00 | 65,443,100.00 | 100.94 | -611,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,231,900.00 | 7,405,100.00 | 89.96 | 826,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,666,600.00 | 3,702,500.00 | 100.98 | -35,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,666,600.00 | 3,702,500.00 | 100.98 | -35,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,666,300.00 | 14,810,200.00 | 100.98 | -143,900.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 28,094,100.00 | 27,365,319.00 | 97.41 | 728,781.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,421,900.00 | 1,444,580.00 | 101.60 | -22,680.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 22,036,400.00 | 21,151,440.00 | 95.98 | 884,960.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,133,100.00 | 2,200,000.00 | 103.14 | -66,900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,262,400.00 | 2,284,299.00 | 100.97 | -21,899.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 240,300.00 | 285,000.00 | 118.60 | -44,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 87,459,400.00 | 66,593,710.00 | 76.14 | 20,865,690.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 67,258,400.00 | 49,796,100.00 | 74.04 | 17,462,300.00 |
| 210502 | Хоол, хүнс | 17,576,000.00 | 14,172,610.00 | 80.64 | 3,403,390.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,625,000.00 | 2,625,000.00 | 100.00 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 935,000.00 | 935,000.00 | 100.00 | |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 935,000.00 | 935,000.00 | 100.00 | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 15,746,000.00 | 15,548,878.76 | 98.75 | 197,121.24 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,828,800.00 | 13,817,178.76 | 99.92 | 11,621.24 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 55,000.00 | 55,000.00 | 100.00 | 0.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,000.00 | 80,000.00 | 100.00 | 0.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 70,000.00 | 58,000.00 | 82.86 | 12,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 30,000.00 | 30,000.00 | 100.00 | 0.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,682,200.00 | 1,508,700.00 | 89.69 | 173,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 14,088,800.00 | 10,269,014.00 | 72.89 | 3,819,786.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,088,800.00 | 10,269,014.00 | 72.89 | 3,819,786.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 80,300,000.00 | 43,668,000.00 | 54.38 | 36,632,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 80,300,000.00 | 43,668,000.00 | 54.38 | 36,632,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 80,000,000.00 | 43,368,000.00 | 54.21 | 36,632,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | 300,000.00 | 100.00 | 0.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,075,004,600.00 | 990,405,444.18 | 92.13 | 85,600,855.82 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 992,962,597.00 | 945,285,214.99 | 95.20 | 47,667,185.01 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 992,952,400.00 | 945,285,214.99 | 95.20 | 47,667,185.01 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 82,052,200.00 | 43,368,000.00 | 52.85 | 38,684,200.00 |
| **1200042** | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 80,000,000.00 | 43,368,000.00 | 53.05 | 36,632,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 2,052,200.00 | 00.00 | 0.00 | 2,052,200.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 1,752,229.19 | | -1,752,229.19 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 29.74 | | -29.74 |

**Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:**

/Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **38,896,800.00** | **38,861,579.46** | **35,220.54** | **99.91** |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 38,896,800.00 | 38,861,579.46 | 35,220.54 | 99.91 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 38,896,800.00 | 38,861,579.46 | 35,220.54 | 99.91 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 35,396,800.00 | 35,370,604.46 | 26,195.54 | 99.93 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 5,076,800.00 | 4,220,604.46 | 856,195.54 | 83.14 |
| 210302 | Түлш, халаалт | 28,160,000.00 | 31,150,000.00 | (2,990,000.00) | 110.62 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,160,000.00 | | 2,160,000.00 | |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 3,500,000.00 | 3,490,975.00 | 9,025.00 | 99.74 |
| 210604 | Урсгал засвар | 3,500,000.00 | 3,490,975.00 | 9,025.00 | 99.74 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **38,896,800.00** | **38,896,800.00** | | |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **38,896,800.00** | **38,896,800.00** | | |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 8,896,800.00 | 38,896,800.00 | | |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 11,293.2 мянган төгрөгийн 7 зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

Нийт 11,293.2 мянган төгрөгийн илрүүлсэн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,647.5 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 1.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт:*

Тус эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэнтэй холбоотой болон бусад шинээр гарсан дүрэм, журамтай нийцэхгүй болсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 ”Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.” заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан дүрэм, журамтай нийцүүлэн шинэчлэн боловсруулж, мөрдөх.

2. **Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт:*

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас интернетийн төлбөр 299.2 мянган төгрөг, бичиг хэргийн материалд 85.0 мянган төгрөг нийт 384.2 мянган төгрөгийн зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх

**3.Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:*

Тайлант жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд бараа үйлчилгээний бусад зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал Эрүүл шүд хөтөлбөрийн 12,355.0 мянган төгрөгийг оруулаагүй баталсан, төсвийн жилийн дундуур төсөвт орсон өөрчлөлтийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж,

батална.", 48 дугаар зүйлийн 48.2.1 "Худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах;" заалт, Сангийн сайдын 2023 оны А/250 тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.11 “Захиалагч цахим системд нийтэлсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллах ба энэ журмын 2.12-т заасан үндэслэлээр батлагдсан төлөвлөгөөнд орсон нэмэлт, өөрчлөлтийг холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын 10 өдөрт багтаан төлөвлөгөөнд өөрчлөлтийг тусган, батална. Хэрэв холбогдох дээд шатны байгууллага байгаа бол төлөвлөгөөний өөрчлөлтийг түүгээр батлуулахаар цахим системээр илгээж, өөрчлөлтийг баталгаажуулна.” гэж заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Тайлант оны төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг төлөвлөх, төсөвт өөрчлөлт орсон тухай бүрт нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлтийг оруулж батлуулж байх.

**1. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийн асуудал**

*Илрүүлэлт:*

2024 онд 1,048,581.7 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас нэхэмжилснээс 38,153.7 мянган төгрөг хасагдсан нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 “эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх;”, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 05 дугаар тогтоолын 3.1 “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны програм, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж,..” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны цахим системийн дотоод хяналтыг сайжруулж, хасагдалтын хэмжээг өмнөх оноос бууруулах.

**2. Нягтлан бодох бүртгэлийн ажилтны урамшууллын талаар**

*Илрүүлэлт:*

Сумын Засаг даргын 2024 оны Б/24 дүгээр захирамжаар эрүүл мэндийн төвийн даргад, Эрүүл мэндийн төвийн даргын тушаалаар нярав, нягтлан бодогч нарт зөвхөн санхүүгийн тайлангийн аудитаар "Зөрчилгүй" дүгнэлт авсан гэсэн шалгуураар 10,909.0 мянган төгрөг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23.2 заалт, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар баталсан журмын 5.1 заалтад заасан шалгуур үзүүлэлт, Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 заалтад заасан “Үр дүнгийн гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц байдалд үндэслэн...”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралт “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.2.1 заалтад “төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид;” мөнгөн урамшуулал

олгохоор заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо аудитын тайланд бичигдсэн болон бусад хяналтын байгууллагаас илрүүлсэн алдаа, зөрчил, өр, авлага, мэдээ, тайлангийн хугацаа, чанар зэрэг үзүүлэлтийг харгалзаж үзэх.

**3. Ахмадын сангийн талаар**

*Илрүүлэлт:*

- Алаг-Эрдэнэ сумын эрүүл мэндийн төв нь ахмадын сан байгуулаагүй байгаа нь Ахмадын настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 “Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах…” гэж заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Байгууллагын төсөвт ахмадын санг төлөвлөж тусгах, сан байгуулах

**7. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Тус сургууль www.shilendans.gov.mn цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 30, зарлагын 5 гүйлгээ хугацаа хоцроож мэдээлсэн, зарлагын 4 гүйлгээг мэдээлээгүй нь нь “Шилэн дансны тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;” заалт, 6 дугаар зүйлийн 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” заалт болон “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** Шилэн дансны хууль, журмыг мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх, ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор оруулж, баталгаажуулна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан дүрэм, журамтай нийцүүлэн шинэчлэн боловсруулж, мөрдөөгүй | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| Эрүүл мэндийн төвийн дарга, нярав, нягтлан бодогч нарт зөвхөн санхүүгийн тайлангийн аудитаар "Зөрчилгүй" дүгнэлт авсан шалгуураар урамшуулал олгосон | 1 | 10,909.0 | | | | | 1 | 10,909.0 |
| Зардлын зориулалт, арга хэмжээнд нийцүүлж зарцуулаагүй байна. | 1 | 384.2 | | | | | 1 | 384.2 |
| **Дүн** | **3** | **11,293.2** | | | | | **3** | **11,293.2** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 30 мэдээлэл , зарлагын 9 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн | 1 | 1,016,771.4 | | | | | 1 | 1,016,771.4 |
| Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд Эрүүл шүд хөтөлбөрийн зардлыг оруулж батлуулаагүй байна | 1 | 12,355.0 | | | | | 1 | 12,355.0 |
| Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас нэхэмжилсэн дүнгээс 38,153.7 мянган төгрөгийн санхүүжилт хасагдсан | 1 | 38,153.7 | | | | | 1 | 38,153.7 |
| Алаг-Эрдэнэ сумын эрүүл мэндийн төв нь ахмадын сан байгуулаагүй байна | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| Дүн | **4** | **1,067,280.1** | | | | | 4 | **1,067,280.1** |

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр № 31/А2070465/ ХОА-2025/027/НА-ОА-ТИЗ Мөрөн сум

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Алаг-Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд бусдаар гүйцэтгүүлсэн бараа, ажил үйлчилгээний төлбөрийн зардал Эрүүл шүд хөтөлбөрийн хүрээнд "ТӨГС МОНГОЛ АНУ" ХХК-тай байгуулсан шүдний үзлэг, эмчилгээний гэрээт ажлын хөлс 12,355,000 (Арван хоёр сая гурван зуун тавин таван мянга) төгрөгийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд оруулж батлуулаагүй, Төрийн худалдан авах ажиллагааны цахим хуудас tender.gov.mn-д байршуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", Сангийн сайдын 2023 оны А/250 тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.11 "Захиалагч цахим системд нийтэлсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллах ба энэ журмын 2.12-т заасан үндэслэлээр батлагдсан төлөвлөгөөнд орсон нэмэлт, өөрчлөлтийг холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын 10 өдөрт багтаан төлөвлөгөөнд өөрчлөлтийг тусган, батална" заалттай тус тус нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "*Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол*" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд орсон нэмэлт өөрчлөлтийг дээд шатны төсвийн захирагчид цахимаар илгээж батлуулж байх, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор гаргаж, төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд оруулж, баталгаажуулах;

2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Алаг-Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн дарга О.Бадмаа, нягтлан бодогч Ц.Анхтуяа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР Г.ИЧИНХОРЛОО

6724020560